Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн даргын 2026 оны 10 дугаар сарын 13 -ны өдрийн А/123 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

9081488 1116128907

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ПОРТАЛ САЙТАД НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү зааврын зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, мэргэжилтний мэдээллийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ирүүлсэн мэдээллийг хянах, баталгаажуулах, нээлттэй мэдээллийн системд байршуулах, шинэчлэх үйл ажиллагааны дараалал, хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү зааврыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журмын хүрээнд мөрдөнө. Үүнд:

1.2.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/155 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”;

1.2.2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/130 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам”;

1.2.3. Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт болон холбогдох бусад үйл ажиллагааг зохицуулсан хүчин төгөлдөр хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэр.

1.3. Энэхүү заавар нь дараах төрлийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэдээллийг бүртгэх, хянах, нээлттэй байршуулах үйл ажиллагаанд хамаарна:

1.3.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага;

1.3.2. Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр сорилт, шинжилгээ хийх лаборатори;

1.3.3. Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт хийх байгууллага;

1.3.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах байгууллага.

1.4. Энэхүү зааварт хэрэглэсэн “портал сайт” гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн цахим систем дэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, мэргэжилтний мэдээллийг бүртгэх, хянах, нийтэд нээлттэй мэдээлэх цахим орчныг ойлгоно.

1.5. Портал сайтад мэдээлэл бүртгэх, байршуулах нь тухайн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, итгэмжлэл олгох, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, эсхүл төрөөс чанарын баталгаа гаргах үйл ажиллагаа биш байна.

1.6. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага мэдээллийг сайн дурын үндсэн дээр ирүүлэх бөгөөд мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн, шинэчлэгдсэн байдлыг хариуцна.

ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭХ

2.1. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг энэхүү зааврын 1.3-т заасан үйлчилгээний үндсэн төрөл, дэд төрөлд хамааруулан бүртгэнэ.

2.2. Нээлттэй мэдээллийн санд бүртгүүлэх хүсэлт, мэдээлэл ирүүлэх тухай урилга, зарлалыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн www.osh.gov.mn цахим хуудас болон portal.osh.mn портал сайтаар дамжуулан түгээнэ.

2.3. Байгууллага нь энэхүү зааврын 1 дүгээр хавсралтад заасан мэдээллийн маягтын дагуу мэдээллээ ирүүлнэ. Шаардлагатай тохиолдолд мэдээллийн үнэн зөвийг нотлох баримт бичгийн хуулбар, холбогдох гэрчилгээ, итгэмжлэл, зөвшөөрлийн мэдээллийг хавсаргана.

2.4. Байгууллага нь өөрийн үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээний үндсэн болон дэд төрлийг сонгож, тухайн үйлчилгээтэй холбоотой мэргэжилтний мэдээлэл, байгууллагын албан ёсны холбоо барих мэдээллийг үнэн зөв ирүүлнэ.

2.5. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэдээллийг хариуцсан эрх бүхий ажилтан ирүүлсэн мэдээллийн бүрэн бүтэн байдал, хоорондын нийцэл, шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянана.

2.6. Ирүүлсэн мэдээлэл дутуу, зөрүүтэй, ойлгомжгүй, эсхүл нотлох баримт шаардлагатай бол мэдээлэл ирүүлсэн байгууллагад засварлах, нэмэлт мэдээлэл ирүүлэх тухай мэдэгдэл хүргүүлнэ.

2.7. Байгууллага нь засварласан болон нэмэлт мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх бөгөөд мэдээллийг хянаж дуусах хүртэл тухайн мэдээллийг нээлттэй байршуулахгүй.

2.8. Бүртгэлд хамрагдсан байгууллагын мэдээлэл нь зөвхөн олон нийтэд мэдээлэл хүргэх зорилготой бөгөөд тухайн байгууллагын үйлчилгээ үзүүлэх эрх, тусгай зөвшөөрөл, итгэмжлэлийн хүчин төгөлдөр байдлыг орлохгүй.

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАХ, БАТАЛГААЖУУЛАХ, НЭЭЛТТЭЙ БАЙРШУУЛАХ

3.1. Портал сайтын нээлттэй мэдээлэлд дараах мэдээллийг байршуулна:

3.1.1. Байгууллагын нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар (шаардлагатай тохиолдолд);

3.1.2. Үйлчилгээний үндсэн болон дэд төрөл;

3.1.3. Үйлчилгээтэй холбоотой мэргэжилтний овог, нэр, мэргэжил, албан тушаал;

3.1.4. Байгууллагын байршил, албан ёсны хаяг;

3.1.5. Байгууллагын албан ёсны утасны дугаар, цахим шуудан, вэбсайт;

3.1.6. Холбогдох итгэмжлэл, гэрчилгээ, зөвшөөрлийн мэдээлэл болон тэдгээрийн хүчинтэй байдлын талаарх мэдээлэл (хамаарах тохиолдолд);

3.1.7. Мэдээлэл шинэчилсэн огноо.

3.2. Мэдээллийг хянах эрх бүхий ажилтан нь ирүүлсэн мэдээллийг холбогдох хууль тогтоомж, журмын шаардлага болон энэ зааварт нийцэж байгаа эсэхийг шалгана.

3.3. Мэдээллийг хянахдаа дараах шалгуурыг баримтална:

3.3.1. Байгууллагын мэдээлэл бүрэн, үнэн зөв байх;

3.3.2. Сонгосон үйлчилгээний төрөл, дэд төрөл нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай нийцсэн байх;

3.3.3. Мэргэжилтний мэдээлэл нь ирүүлсэн баримт бичигтэй нийцсэн байх;

3.3.4. Шаардлагатай тохиолдолд ирүүлсэн итгэмжлэл, гэрчилгээ, зөвшөөрлийн мэдээлэл холбогдох баримтаар нотлогдсон байх;

3.3.5. Нийтэд нээлттэй байршуулах мэдээлэл нь хувийн мэдээлэл хамгаалах болон мэдээллийн аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байх.

3.4. Хяналтын явцад зөрчил илэрсэн бол мэдээлэл ирүүлсэн байгууллагад засвар хийх, нэмэлт мэдээлэл ирүүлэх шаардлага тавина. Шаардлагыг хангаагүй, мэдээллийн үнэн зөвийг тогтоох боломжгүй тохиолдолд мэдээллийг нээлттэй байршуулахгүй.

3.5. Шаардлага хангасан мэдээллийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулсны дараа портал сайтын нээлттэй мэдээллийн хэсэгт байршуулна.

3.6. Нээлттэй мэдээллийн системд байгууллагыг үйлчилгээний үндсэн төрөл, дэд төрөл, байршил болон байгууллагын нэрээр хайх боломжийг бүрдүүлнэ.

3.7. Байгууллагын мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн байгууллага өөрчлөлт гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор мэдээллээ шинэчлэх хүсэлт ирүүлнэ.

3.8. Мэдээлэл хариуцсан ажилтан нь нийтэд нээлттэй байршуулсан мэдээллийн шинэчлэгдсэн байдлыг жилд нэгээс доошгүй удаа хянана.

3.9. Байгууллага үйл ажиллагаагаа зогсоосон, үйлчилгээний төрөл өөрчилсөн, холбогдох итгэмжлэл, гэрчилгээ, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан, эсхүл мэдээллийн үнэн зөвтэй холбоотой үндэслэлтэй зөрчил илэрсэн тохиолдолд мэдээллийг шинэчлэх, засварлах, түр түдгэлзүүлэх, эсхүл нээлттэй хэсгээс хасах асуудлыг холбогдох баримтад үндэслэн шийдвэрлэнэ.

3.10. Нээлттэй мэдээлэлд байршуулсан байгууллага нь мэдээллээ өөрөө шинэчлэх боломжтой системийн шийдэл ашиглаж байгаа тохиолдолд оруулсан өөрчлөлтийг хянан баталгаажуулсны дараа нийтэд нээлттэй болгоно.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

4.1. Портал сайтын администратор болон мэдээлэл хариуцсан ажилтан нь зөвхөн өөрт олгосон эрхийн хүрээнд мэдээлэлд хандаж, мэдээллийг хуульд заасан болон зөвшөөрөгдсөн зориулалтаар ашиглана.

4.2. Нийтэд нээлттэй байршуулах мэдээлэл болон дотоод бүртгэлд хадгалах мэдээллийг ялгаж, хүний хувийн мэдээлэл хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг мөрдөнө.

4.3. Мэргэжилтний мэдээллийг нийтэд нээлттэй байршуулахдаа хуульд заасан үндэслэл, шаардлагатай тохиолдолд тухайн хүний зөвшөөрлийг хангана. Хувийн утасны дугаар, гэрийн хаяг, хувийн цахим шуудан болон нийтлэх шаардлагагүй бусад хувийн мэдээллийг нийтэд байршуулахгүй.

4.4. Системд мэдээлэл оруулсан, өөрчилсөн, хянасан, баталгаажуулсан, устгасан үйлдлийн бүртгэл болон мэдээллийн өөрчлөлтийн түүхийг холбогдох хууль тогтоомж, мэдээллийн аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн бүртгэж, хадгална.

4.5. Портал сайтын хэрэглэгчийн эрх, нууц үг, мэдээллийн сангийн хамгаалалт, нөөцлөлт, мэдээлэл сэргээх ажиллагааг хариуцсан байгууллага зохион байгуулна.

4.6. Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжид нөлөөлөх зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий ажилтан холбогдох журмын дагуу шуурхай арга хэмжээ авч, зөрчлийг баримтжуулна.

4.7. Мэдээллийг хууль бусаар ашигласан, задруулсан, өөрчилсөн, устгасан болон энэхүү зааврыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1. Энэхүү зааврын хэрэгжилтэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн удирдлага болон эрх бүхий албан тушаалтан чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавина.

5.2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь портал сайтад ирүүлсэн мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, шинэчлэлтийг хариуцна.

5.3. Мэдээлэл хянах, баталгаажуулах, нийтлэх, шинэчлэх, устгах үйл ажиллагааг хариуцсан ажилтан нь өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, мэдээллийн үнэн зөв байдал, нууцлал, аюулгүй байдлыг хангана.

5.4. Энэхүү зааврын хэрэгжилттэй холбоотой санал, хүсэлт, мэдээллийн алдааг залруулах хүсэлтийг портал сайтад нийтэлсэн албан ёсны холбоо барих сувгаар хүлээн авч, холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

5.5. Энэхүү зааварт зохицуулаагүй харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

Зааврын хавсралт

№	Байгууллагын нэр	Үйлчилгээний төрөл	Дэд үйлчилгээний төрөл /Итгэмжлэл, эрүүл мэндийн үзлэг, сургалтын чиглэл/	Мэргэжлийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Итгэмжлэгдсэн лабораторитой хамтран ажилладаг эсэх	Тайланг цаг хугацаанд нь өгдөг эсэх	Байршил		Холбоо барих ажилтан	Холбоо барих мэдээлэл
							Аймаг, сум	Дүүрэг		
1		• Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ	• MNS ISO/IEC 17020	• Хөдөлмөрийн эрүүл ахуйч • Мэргэшсэн хөдөлмөрийн эрүүл ахуйч	• Тийм (Лабораторийн нэр) • Үгүй	• Тийм • Үгүй	• 21 аймаг, сум	• Улаанбаатар хот, 9 дүүрэг	• Овог нэр • Албан тушаал	• Хаяг • Утас • И-мэйл • Вэб сайт
		• Лаборатори	• MNS ISO/IEC 17025	• Химич						
		• Эрүүл мэндийн үзлэг, тандалт	• Урьдчилсан үзлэг • Хугацаат үзлэг	• Мэргэжлээс шалтгаалсан өвчний эмч • Хөдөлмөрийн эрүүл мэндийн эмч						
		• Сэргээн засах тусламж үйлчилгээ		• Хөдөлгөөн засалч • Уламжлалтын эмч • Физик эмчилгээний эмч г.м						
		• ХАБЭА-н сургалт	• Нийт ажилтны сургалт • Ажил олгогчийн сургалт • Эрсдэлтэй ажлын байрны сургалт • Хувиараа хөдөлмөр	• Сургагч багш • ХАБЭА-н ажилтан, мэргэжилтэн • Мэргэшсэн ХАБЭА-н ажилтан • Зөвлөх багш, Зөвлөх		• Тийм • Үгүй				

			эрхлэгчдэд зориулсан сургалт • ХАБЭА-н ажилтны сургалт	ХАБЭА-н мэргэжилтэн, Зөвлөх инженер						

-o0o-